

"ШИНЭ СЭРГЭЛТИЙН БОДЛОГО"-ЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЭХНИЙ ҮЕ ШАТНЫ
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨР
Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

2024.12.02-ны өдөрУлаанбаатар хот

Д/д	Үйл ажиллагаа	Хүрэх үр дүн	Биелэлт	Үнэлгээ
ЗУРГАА.ТӨРИЙН БҮТЭЭМЖИЙН СЭРГЭЛТ				
Зорилт 6.1.Төрөөс үзүүлэх үйлчилгээг цахимжуулж, төрийн хүнд суртлыг бууруулна.				
6.1.1	Цахим үндэстэн болох арга хэмжээг эрчимжүүлж, нийтийн мэдээллийн дэд бүтцийг боловсронгуй болгож, цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим харилцаанд шилжиж, нийтийн мэдээллийн системээс олж авах, солилцох боломжтой мэдээллийг иргэн, хуулийн этгээдээс шаардахгүй байх нөхцөлийг хангаж, цахимаар үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмж, тоог нэмэгдүүлж, иргэнийг цахим гарын үсгээр хангах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх.	2020 оны 10 дугаар сарын 01-ний өдөр нээлтээ хийсэн төрийн үйлчилгээний нэгдсэн систем болох "E-Mongolia"-д нэвтрүүлсэн төрийн 57 байгууллагын 563 үйлчилгээг 1000-д хүргэн нэмэгдүүлж, цахим гэрээ хэлцлийг байгуулах нөхцөл бүрдэж, иргэд цаг хугацаа, орон зайнаас үл хамаарч төрийн үйлчилгээг шуурхай авах нөхцөл бүрдсэн байна.	Улсын бүртгэлийн байгууллагын үйлчилгээг цахим хэлбэрээр бүртгэх, бүртгүүлэх боломжийг бүрдүүлэх, мэдээллийн чанарыг сайжруулах, цахим системийн чанарыг дээшлүүлж төрийн үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх зорилгоор Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/, /E-business/-д 123 үйлчилгээг цахим хэлбэрт шилжүүлэн Төрийн үйлчилгээний нэгдсэн портал /E-Mongolia/, /E-business/-аар үзүүлж байгаа бөгөөд 2024 онд нийт 18,075,802 лавлагаа, үйлчилгээг олгосон байна Төрийн мэдээлэл солилцооны (ХУР) систем дэх улсын бүртгэлийн мэдээллийн сангаас гаргаж буй бүх сервист өөрчлөлт оруулж, төрийн болон бусад байгууллага иргэний улсын бүртгэлийн дугаараар мэдээлэл авах боломжтой болж, системээс ашиглагдаж байгаа мэдээллийн 40 гаруй хувь нь улсын бүртгэлийн мэдээллийн сангаас татагдан ашиглагдаж байна. Мөн дундын мэдээллийн санг ашиглан газар эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн дугаар олгох болон Монголын нотариатчдын танхимын 273 гишүүн нотариатч нартай гэрээ байгуулан мэдээлэл солилцон ажиллаж байна. Монгол улсын иргэдэд үнэ төлбөргүй олгох тоон гарын үсгийг улсын бүртгэлийн 104 киоск машин, бусад байгууллагын 1361 ширхэг цахим /киоск/ машинаар тус тус олгодог болсон. Үүнд:	100%

			Гэрэгэ системс ХХК /киоск/-489 Голомт банк АТМ-аар -330 ХААН банкны АТМ-аар-442 ТҮЦ-100 Улсын бүртгэлийн цахим үйлчилгээний 104 ширхэг киоск машиныг улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр шийдвэрлүүлж, программ хангамжийг суулгаж, бүх тохиргоог хийж, шаардлагатай нэгжүүдэд хуваарилж, ашиглалтад оруулан анхан шатны нэгжүүдэд байршуулан, 29 төрлийн лавлагаа, үйлчилгээг үзүүлж байна. Үүнд: - Лавлагаа-20 /Иргэний улсын бүртгэл-12, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-6, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-2/ - Үйлчилгээ-9 /Иргэний улсын бүртгэл-4, Хуулийн этгээдийн улсын бүртгэл-2, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэл-3/ УБЕГ-ын 24/7 төв, Хан-Уул дүүргийн улсын бүртгэлийн хэлтэс, Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Чингэлтэй дүүргийн Улсын бүртгэлийн хэлтэс, Улаанбаатар төмөр замын вокзал, Сүхбаатар аймгийн Улсын бүртгэлийн хэлтэс, Өмнөговь аймгийн Ханбогд сумын “Гашуун сухайт” боомтод тус тус гадаад паспорт өөртөө захиалах цахим КИОСК 7 машин суурилуулан иргэдэд үйлчилгээг үзүүлж байна. Цахим гарын үсгийн тухай хуульд заасны дагуу 2022.05.01-ний өдрөөс 2024.11.24-ний өдөр хүртэлх хугацаанд Монгол Улсын 16 нас хүрсэн тоон гарын үсгийн гэрчилгээ авах хүсэлт гаргасан 1,439,716 иргэнд тоон гарын үсэг олгосон. Үүнээс гар утсаар 566,659 иргэний үнэмлэхэд 873,057 /киоскоор 106,836/	
6.1.3	Хаягийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх.	Улсын хэмжээнд хаягжуулалтын ажлыг нэгдсэн тогтолцоонд шилжүүлж, хэрэгжүүлсэн байна.	МУ-ын Ерөнхий сайдын 2024 оны 60 дугаар захирамжаар "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлэх тухай" Засгийн газрын 2022 оны 180 дугаар тогтоолын хэрэгжилтийг эрчимжүүлэ, салбар хоорондын холбогдох үйл ажиллагааг уялдуулах ажлыг зохион байгуулах, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулагдсан бөгөөд нарийн бичгийн даргаар УБЕГ-ын дарга	70
6.1.4	Хиймэл оюун ухаан, блокчейн болон газар зүйн мэдээллийн системд суурилсан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ,	Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэлтэй 500 мянга гаруй барилгын зурган болон бүртгэлийн мэдээллийг засварлаж, өгөгдлийн санг		

	татвар, төлбөрийн нэгдсэн системийг олон улсын жишигт нийцүүлэн хөгжүүлэх.	байгуулан 3 болон 4 хэмжээст газар, үл хөдлөх хөрөнгийн бүртгэл, үнэлгээ, татвар, төлбөрийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлж, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудын системтэй холбосон дундын мэдээллийн санг байгуулж, салбар хоорондын уялдааг хангасан байна.	ажиллаж байна. Тус ажлын хэсгийн анхдугаар хурал 2024.11.22-ны өдөр зохион байгуулагдаж, УБЕГ-ын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч У.Болдхүү болон Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн газрын дарга Б.Ариунболд нар оролцож "Хаягийн мэдээллийн сангийн нэгдсэн системийг Улсын бүртгэлийн ерөнхий газартай холболт хийж дундын мэдээллийн санг байгуулах ажлын талаарх танилцуулга"-ыг хийсэн. УБЕГ, ГЗБГЗЗГ-ын даргын хамтарсан 2022.05.31-ний өдрийн А/118, А/462 дугаар тушаалаар байгуулагдсан Хаягийн болон газар, үл хөдлөх эд хөрөнгийн дундын мэдээллийн сан байгуулах чиг үүрэг бүхий ажлын хэсэг нь 2024.11.20-ны өдрийн байдлаар 4 удаа уулзалтыг зохион байгуулсан. Уг уулзалтуудаар газрын кадастрын мэдээллийн системд өмчлөлийн газрын бүртгэл мэдээллийг түүхчилсэн байдлаар хөрвүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийн үнэн зөв бүртгэхэд бүртгэлийн байгууллагаас гарах өгөгдөл мэдээллийг авах замыг тодорхойлж, мэдээлэл солилцохоор Үндэсний дата төвд байрлах баазад газрын үйлчилгээний түүхчилсэн мэдээллийн сервисийг үүсгэж, ГЗБГЗЗЕГ-аас авах хаягийн мэдээллийн багануудыг тодорхойлж хүргүүлсэн. Хаягийн санг нэгтэх зорилгоор улсын бүртгэлийн цахим мэдээллийн сан дахь кадастрын дугааргүй бүртгэлийг нөхөж оруулах ажлын явц 2024.11.20-ны өдрийн байдлаар нийт 128,783 нэгж талбарын дугаар буюу нийт нөхөж оруулах шаардлагатай бүртгэлийн 62.7 хувийг нөхөж оруулаад байна. Эд хөрөнгийн хаяг өөрчлөгдөх бүртгэл 2024.11.20-ны өдрийн байдлаар өссөн дүнгээр 7,666 хаяг өөрчлөгдсөн бүртгэл хийгдсэн байна.	
Дундаж үнэлгээ хувиар				85
Оноо				4.25

--oOo--